

УЛС ТӨРИЙН ХОШУУЧЛАГЧИЙН ИМИЖ

Г.ЭРДЭНЭБАЯР

Доктор, дэд проф. МУНС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбар,

Философиийн тэнхим

З.ЛХАГВАДОРЖ

Докторант

Түлхүүр үгс: Улс төрийн имиж, хошуучлагчийн имиж төлөвшил, PR, олон нийтийн харилцаа

Товч утга: Энэхүү өгүүлээр орчин үеийн улс төрийн хошуучлагчийн имиж төлөвшлийн онол, үзэл баримтлалын суурин дээр, нэр дэвшигчдийн сурталчилгаа, олон нийтийн санаа бодлын хандлагын талаар авч үзсэн болно. Ингэхдээ сонгогчид болон сонгуульд нэр дэвшигчидийн, хошуучлагч хийгээд олон нийт дэмжигсэд хоорондын харилцааг тодотгож байгаа имижийг улс төрийн шинжлэх ухааны үүднээс судалж, үүнийгээ гадаадын орны болон Монгол орны жишээн дээр авч үзсэн чухал ач холбогдолтой юм.

**Abstract:** Images have consistently been accused of having enormous power over human minds, as in Plato's parable of the cave. Contemporary democratic politics are often characterized as "image politics", in which style matters more than substance, and personalities more than policies. Citizens and electorates are said to be in the thrall of political images. Whereas in the cases of Fascist Italy and Nazi Germany such image politics have been considered as symptomatic of those pathological political forms, they are often regarded as pathologies of democratic politics that should be eradicated or contained.

Arguments about the deleterious effects of images on politics often entail claims that whoever is satisfied with such polities is subject to the mystification of ideology or idols. Those who cannot see through the images that dominate politics, according to these critiques, know no better than to worship idols, to make a fetish of images, or to mistake false images and ideas for reality. In contrast, those who can see through the images appear to themselves to be perspicacious, enlightened and mature.

\*\*\*\*\*

Имиж нь сонгогчид болон нэр дэвшигчидийн, хошуучлагч хийгээд олон нийт дэмжигсэд хоорондын харилцаа, харьцааны "хэл", "холбогч гүүр" нь юм. Тиймээс имижид нийгэм олон нийтийн ч хошуучлагч улс төрчийн ч аль алины эрх ашиг сонирхол адил тэнцүү тусгагдаж байх учиртай. Мэдээж хошуучлагчийн эрх ашиг хэдийтвэл хаалттай, дарангуйлагч нийгэм, тогтолцооны мөн чанар болно. Харин ардчилсан нийгэмд төрийн бодлого шийдвэр, үйл бүхэнд иргэд, олон нийтийн үүрэг оролцоо тэргүүн зэрэгт тавигдах учиртай. Тиймээс олон нийтэд хандсан мэдээлэл, улс төрийн аливаа үйл, бодлого нь тэдний эрх ашиг, сонирхолын хариу, хүсэлт хүлээлт байх ёстой. Өөрөөр хэлбэл хүмүүс өөрсдийн сонсож мэдрэхийг хүсч буй зүйлээ илүү анхаарч, ойлгож басхүү итгэж үнэмшдэг гэсэн үг. Негеө болдоор олон нийтийн санаа бодлыг хүлээлт эрэлтийн орон зайг хэр нөхнө, тэр чинээгээр хошуучлагч, оройлогч болдог нь аль нийгэм, ямар ч цагийн мөн чанар юм.

Өнөөгийн Монголын нийгэм, олон нийт шударга, "аврагч", бүгдэд хүлээн зөвшөөрөгдсөн (харизмат) удирдагчийг эрэлхийлж буй нь нэг талаас улс төрийн имижийн гол үндсэн хандлага, нөгөө талаас улс төрч хэн бүхний тэмүүлэх орон зай, өрсөлдөөний зорилго, шалтгаан болж байна. Энэхүү зорилго, орон зайд хүрэх хоёр үндсэн арга зам буй бөгөөд тэр нь олон нийттэй хэрхэн харилцах асуудалд төвлөрдөг. Тиймээс хаалттай (олон нийтээс далд, бишрэл хүндэтгэлийг олох) нээлтгэй (олон нийтэд ойр, итгэл олон хүлээн зөвшөөрөгдхөк) гэсэн хөтөлбөрт имижийг хуваан үздэг. Мэдээж эхнийх нь дарангуйлагч, авторитари улс төрийн тогтолцооны хошуучлагчийн гол "чанар", хоёр дах нь ардчилсан нээлтгэй улс төрийн хошуучлагчийн нэр хүнд болно. Тиймээс ч 1990-ээд оноос хойш манай улс төрийн харилцаанд нэр дэвшигч, "хошуучлагч" хэн боловч ард түмэнтэйгээ ойр, тэдний нэг, нутгийн хүү, олон түмний төлөөлөл хэмээх имижийг бий болгохыг эрмэлзэн зорьсон түүх үргэлжилж байна.

Судлаач Э.Сэмпсон<sup>1</sup> улс төрийн имижийг хувь хүний, үнэлэлт ойлголтын, хэрэгцээг бий болгох гэсэн гурван хэлбэр хүрээнд томъёолжээ. Эхнийх нь мэдээж хувь хүний амьдрал туршлага, мэдлэг болоод өөрийн дотоод өргөнцийн үнэлэлт, итгэл сэтгэлтэй хоёрдахь нь бусдын, олон нийтийн байр суурь, хандлагатай, гуравдахь нь цаг үе, нөхцөл байдлаас шалтгаалан бий болгох зайлшгүй хэрэгцээтэй холбоотой юм. Шинээр бий болгох ёстой имижд хувцас эдлэл дүр төрх гээд харахуйн тэмдэгт мэдээллийн иж бүрдэл онцгой чухал бөгөөд олон нийтийн санаа бодолд хүрэх хялбар түгээмэл арга

<sup>1</sup> Sampson.E . The image factor L.1994.p128

УЛС ТӨРИЙН ХОШУУЧЛАГЧИЙН ИМИЖ

Г.ЭРДЭНЭБАЯР

Доктор, дэд проф, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбар,

Философиийн тэнхим

З.ЛХАГВАДОРЖ

Докторант

Түлхүүр үгс: Улс төрийн имиж, хошуучлагчийн имиж төлөвшил, PR, олон нийтийн харилцаа

Товч утга: Энэхүү өгүүлээр орчин үеийн улс төрийн хошуучлагчийн имиж төлөвшлийн онол, үзэл баримтлалын суурин дээр, нэр дэвшигчдийн сурталчилгаа, олон нийтийн санаа бодлын хандлагын талаар авч үзсэн болно. Ингэхдээ сонгогчид болон сонгуульд нэр дэвшигчидийн, хошуучлагч хийгээд олон нийт дэмжигсэд хоорондын харилцааг тодотгож байгаа имижийг улс төрийн шинжлэх ухааны үүдиэс судалж, үүнийгээ гадаадын орны болон Монгол орны жишээн дээр авч үзсэн чухал ач холбогдолтой юм.

**Abstract:** Images have consistently been accused of having enormous power over human minds, as in Plato's parable of the cave. Contemporary democratic politics are often characterized as "image politics", in which style matters more than substance, and personalities more than policies. Citizens and electorates are said to be in the thrall of political images. Whereas in the cases of Fascist Italy and Nazi Germany such image politics have been considered as symptomatic of those pathological political forms, they are often regarded as pathologies of democratic politics that should be eradicated or contained.

Arguments about the deleterious effects of images on politics often entail claims that whoever is satisfied with such politics is subject to the mystification of ideology or idols. Those who cannot see through the images that dominate politics, according to these critiques, know no better than to worship idols, to make a fetish of images, or to mistake false images and ideas for reality. In contrast, those who can see through the images appear to themselves to be perspicacious, enlightened and mature.

\*\*\*\*\*

Имиж нь сонгогчид болон нэр дэвшигчидийн, хошуучлагч хийгээд олон нийт дэмжигсэд хоорондын харилцаа, харьцааны "хэл", "холбогч гүүр" нь юм. Тиймээс имижид нийгэм олон нийтийн ч хошуучлагч улс төрчийн ч аль алины эрх ашиг сонирхол адил тэнцүү тусгагдаж байх учиртай. Мэдээж хошуучлагчийн эрх ашиг хэдийтвэл хаалттай, дарангуйлагч нийгэм, тогтолцооны мэн чанар болно. Харин ардчилсан нийгэмд төрийн бодлого шийдвэр, үйл бүхэнд иргэд, олон нийтийн үүрэг оролцоо тэргүүн зэрэгт тавигдах учиртай. Тиймээс олон нийтэд хандсан мэдээлэл, улс төрийн аливаа үйл, бодлого нь тэдний эрх ашиг, сонирхолын хариу, хүсэлт хүлээлт байх ёстой. Өөрөөр хэлбэл хүмүүс өөрсдийн сонсож мэдрэхийг хүсч буй зүйлээ илүү анхаарч, ойлгож басхүү итгэж үнэмшдэг гэсэн үг. Негээ бодлоор олон нийтийн санаа бодлыг хүлээлт эрэлтийн орон зайг хэр нөхнө, тэр чинээгээр хошуучлагч, оройлогч болдог нь аль нийгэм, ямар ч цагийн мөн чанар юм.

Өнөөгийн Монголын нийгэм, олон нийт шударга, "аврагч", бүгдэх хүлээн зөвшөөрөгдсөн (харизмат) удирдагчийг эрэлхийлж буй нь нэг талаас улс төрийн имижийн гол үндсэн хандлага, негээ талаас улс төрч хэн бүхний тэмүүлэх орон зай, өрсөлдөөний зорилго, шалтгаан болж байна. Энэхүү зорилго, орон зайд хүрэх хоёр үндсэн арга зам буй бөгөөд тэр нь олон нийтгэй хэрхэн харилцах асуудалд төвлөрдөг. Тиймээс хаалттай (олон нийтээс далд, бишрэл хундэтгэлийг олох) нээлттэй (олон нийтэд ойр, итгэл олон хүлээн зөвшөөрөгдөх) гэсэн хөтөлбөрт имижийг хуваан үздэг. Мэдээж эхнийх нь дарангуйлагч, авторитари улс төрийн тогтолцооны хошуучлагчийн гол "чанар", хоёр дах нь ардчилсан нээлттэй улс төрийн хошуучлагчийн нэр хүнд болно. Тиймээс ч 1990-ээд оноос хойш манай улс төрийн харилцаанд нэр дэвшигч, "хошуучлагч" хэн боловч ард түмэнтэйгээ ойр, тэдний нэг, нутгийн хүү, олон түмний төлөөлөл хэмээх имижийг бий болгохыг эрмэлзэн зорьсон түүх үргэлжилж байна.

Судлаач Э.Сэмпсон<sup>1</sup> улс төрийн имижийг хувь хүний, үнэлэлт ойлголтын, хэрэгцээг бий болгох гэсэн гурван хэлбэр хүрээнд томъёолжээ. Эхнийх нь мэдээж хувь хүний амьдрал туршлага, мэдлэг болоод өөрийн дотоод ертөнчийн үнэлэлт, итгэл сэтгэлтэй хоёрдахь нь бусдын, олон нийтийн байр суурь, хандлагатай, гуравдахь нь цаг үе, нөхцөл байдлаас шалтгаалан бий болгох зайлшгүй хэрэгцээтэй холбоотой юм. Шинээр бий болгох ёстой имижд хувцас эдлэл дүр төрх гээд хараахуйн тэмдэгт мэдээллийн иж бүрдэл онцгой чухал бөгөөд олон нийтийн санаа бодолд хүрэх хялбар түгээмэл арга

<sup>1</sup> Sampson.E . The image factor L.1994.p128

зам байдаг. Ер нь “image” хэмээх англи үн нь “толинд харагдах дур” гэсэн утгыг тээдэг нь ч санаандгүй хэрэг бус. Түүнчлэн бие галбир төрх, нүдний харц, алхаа гишгээ гээд хүнийг тодорхойлох “биений хэл тэмдэгт” үргэлжилнэ. Тэгээд ч имижээр улс төрийн харилцаанд олон асуудлыг тодорхойлж шийднэ.

Гэхдээ имижээр бүхийг шийднэ гэвэл эндүүрэл болно. Имиж бол мэдээлэл, билэгдэл, түүний үр нөлөөг харилцааны орчин болох нийгэм, цаг үе шийдэх бөгөөд тэр нь хүнтэй хүний ертөнц, мөн чанараын олон хүчин зүйлтэй холбогдоно. Тухайлбал сүү хэрэглэх нь кока кола, пепсиగээс илүү чухал, эрүүл мэндэд хэрэгтэйг бүгд зөвшөөрдөг ч хэрэглээ нь бага, буурсаар байгаа аж. Өөрөөр хэлбэл суүний имиж өсөх тусам худалдаа хэрэглээ нь буурч байгаа бөгөөд энэ нь тослог, таргалалтын нэг тайлбар болж байгаатай холбоотой. Мөн Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж баяр ёслол, наадам цэнгээнийг архиар бус суүгээр дээжилж байх уриа, үзэл санааг онцолж буйг хүн бүр хүлээн зөвшөөрдөг амьдралд тэр бүр бодит үйл болохгүй л байна. Тэгэхлээр зөвхөн имижийг бий болгох, өөрчлөх нь хангалттай бус түүний цаана буй зан үйл хэрэгцээ, хэрэгтээг шинэчлэх нь чухал ажгуу. Энэ нь улс төрийн имижд мөн адил хамаарах ба дүр, нэр хүндээс гадна түүний бодит ахуй, эрэлт, хүсэлт, хүлээлтийг олон нийтийн санаа бодлод “суулгах” хэрэгтэй. Ийм шалтгаан үндэслэлээр гуравдахь Ерөнхийлөгч Н.Энхбаярын шударга ёс, авилгайтай тэмцэх үзэл санаа бүхий имиж, МАНын дарга М.Энхболд шинэчлэл ардчиллын “имиж”. Ерөнхий сайд Н.Алтанхуягийн эдийн засгийн хөгжил дэвшлийн тухай яриа “хоосон зүйл”, бодит бус дүр төрх болж байна,

### **Имиж бүрдүүлэх арга зам, үе шат**

Имиж нь тухайн цаг үе нийгмийн эрэлт, тусгал байх ёстой. Тиймээс мэдээлэл харилцааны агуулга хэлбэр болоод гүйцэтгэл нь нэг талаас олон нийтийн санаа бодлын хүсэлт, эрэлт нөгөө талаас хошуучлагчийн эрх ашиг, боломж, зайлшгүй тодотох гэсэн хоёр асуудлын иэгдэлд чиглэнэ. Имижийг бий болгох арга замыг дараах үе шат байдлаар тодорхойлно. Үүнд:

- Зорилгот бүлэг, хүрээ, сонгогчдын эрх ашиг байр суурийт тодорхойлох
- Имижийн бүрдэл, “агуулга, хэлбэр”-ийг томъёолох
- Илэрхийлэл, түгээлтийн (харанхуйн, үзэл санааны, үйл явдлын, гэр бүлийн) бодлого

Юуны өмнө зорилгот бүлэг, сонгогчдын хүрээ бүр өөрийн эрх ашиг сонирхол хүлээлт буйг мэдэж тогтоох нь үр нөлөө бүхий мэдээлэл харилцааны эх сурвалж болохыг хэлмээр байна.

Оросын улс төрийн хошуучлагчдын хувьд бие хүний (хөрөг), мэргэжлийн, нийгмийн гэсэн гурван хүрээнд имиж. нэр хүндийг тогтоодог<sup>2</sup> аж. Үүнд:

Бие хүний хувьд	Мэргэжийн хувьд	Нийгмийн хувьд
- Шударга	- Ажил хэрэгч	- Хүмүүст эзэгэг
- Үзүүч	- Нэр хүндтэй	- Ард түмэнд ойр
- Боловсролтой	- Ажилсаг	
- Хүнзэг		
- Хариуцлагатай		
- Шийдвэргий		
- Ухаалаг		
- Өгөөмөр, ашиг завшаан үл хайгч		
- Эрчтэй		
- Зарчимч		
- Залуу		
- Хумуус өөртөө татагч		
- Нээлттэй		

Мөн имижийг өрсөлдөгч талынхаа сул тал, хоосон орон зайд үндэслэн бий болгох боломжтой. Энэ нь тодорхой нөхцөл шалтгаанаар, тодруулбал сонгуулийн сурталчилгааны үеэр илүү боломжтой арга хэлбэр бөгөөд үүнийг ч Р.Рейган өмнөх үеийнхээ өрөнхийлөгч нараас давуу чанартайгаа нотлон харуулснаар амжилтад хүрсэн нь бий. Украины Ерөнхийлөгчийн сонгуульд ч Л.Кучма Л.Кравчукийг үндэсний үзлийг илүү талархдагаараа ялсан бол Б.Ельцин ардчиллыг дэмжигч, тэрс үзэлтэн байсан гэдгээрээ өрсөлдөгчөө давсан түүх бий. Тиймээс ялж болох хэн нэгэн нь өрсөлдөгчийнхөө дутуу, сул

<sup>2</sup> Политическое консультирование М. 1999. 162-163

талд дөрөөлөн имижээ босгох нь улс төрийн харилцаанд эерэг үр дүн авчирдаг жам бий. Гэхдээ үүнд хүрэхэд хувь улс төрчийн уран илтгэх, бусдыг татах увьдис болоод мэдлэг боловсрол туршлага чухал нөлөөтэй нь ойлголмжтой. Ийм улс төрчийн жишээнд Б.Клинтон, Кол. Ж.Кеннеди, В.В.Путин гээд дэлхийн, Ц.Элбэгдорж, С.Баяр зэрэг монголын хошуучлагчдыг тоочиж болно.

Имижийг бүрдүүлэгч хамгийн чухал суваг, хэрэглүүр нь харахуйн тэмдэгт илэрхийлэл билээ. Харах тэмдэгтэд дараах давуу тал байдаг. Үүнд:

- Утга, үгийн орчуулга, тайлбар хэрэггүй
- Харахуйн тэмдэгт билэгдлийг хүмүүс илүү тогтоодог
- Илүү их агуулга, мэдээллийг (зарим үед үг хэлээр илэрхийлж боломгүй) түгээдэг
- “Харах” мэдээлэл хүний сэтгэл зүйл шууд нөлөөлдөг эдгээрийг тэмдэглэж болно.

Харахуйн дүр байдал нь эртийэс хүмүүсийн сэтгэл зүйл, санаа бодолд нөлөөлж ирсэн. Шашин, сүсэг бишрэлийн хүрээнд ч өргөн ашиглагдаж ирсэн. Будлын шашны бурхдын дүр байдал, өнгө, суудал, хөдөлгөөн гээд бүгд сүсэгтний итгэл бишрэлийг өдөөх, нөлөөлөх утга, хэлбэрийн зорилгод бүрнээ нийцдэг. Шашин сүм хийдийн билэг тэмдэг нь ч аврал, амар амгалан, жаргалын утга агуулга болоод зан үйлийн тэргүүлэгч, түүнээ цогцол юм.

Билэг тэмдэг нь улс төрийн намын хувьд ч онцгой чухал, нөлөөллийн “зэвсэг” байдаг. АН-ын морьтон, МАН-ын улаан өнгө. ИЗН-ын С.Зоригийн дүр зэрэг нь утга агуулга, итгэх үзүүлэлтийн нөлөөтэй. АНУ-ын хоёр гол намын билэг тэмдэг ч илжиг болоод заан байдаг. Их Британы лейборист намын сарнай гээд байdag учиртай. Монголын улс төрийн рекламиын орон зайд хүлэг морь онцгой байр суурь эзэлдэг нь нүүдэлчин соёл, эртний эзэнт гүрэн, хурд хүч, ирээдүйн билэг тэмдгийн илэрхийлэл болдогт оршино. Гэхдээ морио хотлох үү, унах уу, дэлийг нь засах уу гээд олон утга билэгдлийн аль нэгийг сонгосноор утга илэрхийллийн өөр өөр хувилбарт хүрнэ. Мөн хурдан удмын даагаа бэлэглэх, адuu уураглах, хураах, хөтөлгөө, морьтой давхих гээд билэгдэл утгыг дэлгэрүүлж болно.

Өнөөгийн хүн телевизээс гол мэдээлтээ авч, түүгээр үнэлэлт дүгнэлт, төсөөллөө тодорхойлдог. Тиймээс мэдээллийн хөтөлбөр, ярилцлагын дүр төрх нь шийдвэрлэгч, нөлөөллийн “хүчирхэг” хэрэглүүр болж байна. Өөртөө итгэлгүй ядарсан, идэвхгүй дүр байдал нь олон нийтэд эргэлзэх, үгүйсгэх сэдэл шалтагийг шууд өдөөнө. Нэн ялангуяа олон хоногийн ажлын айчлал, сурталчилгааны дараа сэтгэл зүйн ачаалал, нойргүйдэл, ядаргаа зэрэгээс шалтгаалж хэн ч тэр “ядруухан” харагдах нь ойлголмжтой тул дурангийн өмнө “зүсээ засах” нь улс төрчийн хувьд санаж явах зарчим бөлгөө.

Телевиз нь мэдээллийн агуулга ба мэдээлэгчийн (улс төрч, хошуучлагчийн) дүр байдлын нэгдлийг бий болгох боломжийг олгосон нь улс төрийн амьдрал, харилцаанд томоохон өөрчилэлтийг авчирсан. Тиймээс ч улс төрч, нэр дэвшигчийн гадаад дүр төрхийн “нүдэнд дулаахан байх”, харагдах гэсэн шалгуурыг бий болгов. Үүний анхны жишээ, нотолгоо нь Никсон болоод Кеннеди нарын телевизийн халз мэтгэлзээн билээ. Үүнийг судлаачид телевизийн дүр төрх, биений болоод нүүрний хөдөлгөөн, харагдах байдал (Кеннеди залуу) зэрэгтэй холбон, эмэгтэй сонгогчдод таалагдсан гэсэн тайлбараар нотолдог. Өөрөөр хэлбэл телевизийн дурангийн өмнө нэр дэвшигч сэтгүүлчидтэй бус харан үзэгчидтэй харилцаж буйгаа байнга санаж, дүр байдлаа илэрхийлэх хэрэгтэй гэсэн үг. Орчин үеийн улс төрчид ч телевиз, гэрэл зурийн нөлөө, ая холбогдлыг онцолж, түүнээ нийт төсвийнхөө ихэнх хувийг зарцуулж байна. АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх мэдээлэл харилцаанд л гэхэд 1990-ээд оноос хойш нэр дэвшигчид нийт төсвийнхөө 60-80 хувийг телевизийн сурталчилгаанд зарцуулж байна.

Гэхдээ нэвтрүүлэг мэдээллийн хэрэгслээр олон дахин гарахдаа бус, сайн сайхан, эерэг таатай асуудлаар ерөнхийдөө ярихдаа ч бус хамгийн гол нь зорилгот, хэрэгтэй бүлэг, сонгогчдод сонсохыг, мэдэхийт хүсч буй мэдээллийг түгээх, илэрхийлэхдээ ажлын үндсэн үүрэг даалгавар оршдог. Тэгхлээр суваг хэрэгсэл нь зорилгот бүлэг ба нөлөөхүйц мэдээлэл хоорондын “гүүр”. нэгтгэгч хүчин зүйл нь болно. Тиймээс М.Тэтчер телевизийн оройн хөтөлбөрийг идэвхитэй “ашиглаж”, Р.Рейген сонгогчддоо өмнөдийнхөн, католикууд мэргэжлийн ажилчид гэсэн гурван хүрээнд ангилж, амжилт олсон гэдэг.

Өөр нэгэн зүйл нь олон нийтийн сонирхол, эрх ашигт нийцсэн мэдээллийг түгээх сонгох юм. Улс төрийн бус харин хүний тухай мэдээллийг олон нийт сонирхдог. Улс төрийн үзэл санаа бус харин хүний амьдрал, хувь тавилан, ялалт, ялагдал олон нийтэд сонирхолтой байдаг. Үнэхээр ч Н.Багабандийн залуу насны өргөн жинс, урт үстэй зураг. Ц.Элбэгдоржийн хүримын хөрөг, Н.Энхбаярын малчин өвгөнтэй хөөрөг зөрүүлж буй агшин гээд олон нийтэд энгийн мөртлөө эгэлгүй нөлөө үзүүлсэн жишээ олон “би бусдын л адил” гэсэн утга, дүр билэгдлийг үзүүлэх нь орчин үеийн улс төрийн хошуучлагчийн олон нийтэд нөлөөлөх, зэрэг таатай харилцаа, сэтгэгдлийг төрүүлэх нэгэн зорилго болоод байна.

Мэдээж цаг үе, нөхцөл байдалд хандах улс төрч ба жирийн сонгогч хоорондын байр суурь, үнэлэлт

ялгаатай. Сонгогч үг үйлдэл бүрийг нарийн иягталж, ойлгоод байдагтүй. Тэгээд ч сонгогч хин боловч улс төрийн мэдээлэл, харилцаанаас “зугтх” үгүйсгэх мөн чанартай болой. Тиймээс улс төрчдийн ярж, онцолж буй агуулгыг үнэлж дүгнэх бус харин нэгэнт тогтсон өөрийн байр суурь, тесеэллээр бүхнийг тодорхойлохыг эрмэлзэдэг. Улс төрчид ч тэрхүү олон нийтийн тесеэлэл, ойлголтоор эрэмбэлэгдэдэг. Харин тэрхүү эрэмбийг тогтоогч нь ОНМХ байдал. Өөрөөр хэлбэл бидний нийгэм цаг үе нь мэдээллийн, телевизийн, интернэтийн гэхээсээ илүү мэдээлэл, телевиз, интернэтийн бий болгооди “бодит байдал. орон зайд” болжээ.

Олон нийтгэй харилцах, сонгогчдыг татахад шинэ санаа, баримт, нотолгоо чухал юм. Тийнхүү учир зүйн нотолгоотой, “шугаман”, зөв ончтой санаа дэвшүүлэх нь хошуучлагчийн олныг дагуулах үндэслэл, шалтгаан болно. 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулыд Ц.Элбэгдорж “илүү хийг хийн, эхэлсэнээ гүйцээнэ” Б.Бат-Эрдэнэ “нэр цэвэр”. С.Удвал “эмэгтэй хүн” гэсэн санааг нийгэмд хүртэсэн нь сонгуулийн дүнгээр аль үнэ цэнэтэй вэ гэдгийг эрэмбэлсэн гэхэд хилслэхгүй.

#### **Дүгнэлт: Улс төрийн харилцааны онцлог, Jr и голоо**

Улс төрийн имиж нь мэдээллийн давамгайлал, түшинэд тулгуурлсан зорилго, амжилтад хүртэгжам зарчимтай үйл хэрэг юм. Тиймээс ч мэдээллийн дайн довтолгоо хэмээн нэр томъёо гарч, бодит амьдралд орших болсон. Мартын Либицки<sup>3</sup> “мэдээллийн давамгайлал” нь цэрэг дайны зорилго, давуу байдлын төлөөх түгээлт, төөрөгдүүлэлт, хэрэгтээний давуу байдлыг бий болгох, хадгалах үйл явц хэмээн тодорхойлсон нь улс төрийн харилцаанд ч ашиг утгатай юм. Үүнийгээ тэрээр гурван онцлог ойлголтын хүрээнд авч үзсэн ба нэгдүгээрт мэдээллийн нөлөөг шууд үгүй хийх, өөрчлөх боломжгүй. Хоёрдугаарт өрсөлдөгч аль ч талууд мэдээллийн бодит орон зайд тулгуурлан бодлого, үйл ажиллагаагаа тодорхойлно. Тэр дундаа хүчтэй тал нь шлүү хүчин чармайлт гаргана. Гуравдугаарт хүний хүчин зүйл бүхнийг тодорхойлно гэж томъёолжээ. Өөрөөр хэлбэл имискийн төлөөх өрсөлдөөн нь мэдээллийн давамгай түшицэд байр сууриа тодорхойлох зорилгот бодлого, үйл асуудал гэсэн үт. Тэгээд ч энэхүү өрсөлдөөнт орчинд аль нэг имиж, үзэл санаа ялах эсэх нь мэдээллийн давамгай түшиц, түүний нөлөөллөөс шалтгаалдаг.

Ерөнхийлөгчийн албан тушаал бол улс төрийн дээд оргил, нэр хүнд, имижийн тэргүүлэгч төвшин юм. Тиймээс ч Ерөнхийлөгчийн сонгуулийн компанийн ажилда хүчин тоголдор Ерөнхийлөгчийн байр суурь давамгай, нөлөө бүхий байдал. Ийм жишээ АНУ-д Эйзенхауэр, Р.Никсон, Л.Жонсон, ОХУ-д В.В.Путин, В.Ельцин харин Монголд Н.Багабаиди, Ц.Элбэгдорж нарын дахин сонгууль баталсан. Ер нь ямарч улс орон нийгэмд улс төрийн имижийн гол үндсэн загвар, хэмжээ төвшин Ерөнхийлөгчийнхөөр тодорхойлогддог. АНУ-ын хувьд нэр хүнд, эрч хүч эрэ шийдвэлгийг байдал зэрэг нь Ерөнхийлөгчийн гол үндсэн имиж байдал бол ОХУ-д энгийн, шууд, шударга, шийдвэмгийн хатуу чанд зарчимч чанарыг онцгойлон үздэг. Өөрөөр хэлбэл үндэсний зан сэтгэхүйн онцлог, улс орны үнэт зүйл Ерөнхийлөгчийг тодорхойлох гол үнэлэгт шалгуур бодлог.

Монголын улс төрийн PR-ыг хошуучлагч (лидер) төвт үндэсний болоод төрийн дээдлэгч байр суурь бүхий мэдээлэл харилцаа хэмээж болно. Өнөөг хүртэл хошуучлагчийн төгс, эрхэмлэлт үлгэр жишээ, ухаан Чингис хаан, “Монголын шууд товчоо” хэвээр байгаа нь. түүнээ өгүүлдэг үзэл санаа, үнэлэмж улс төрийн харилцаанд үнэ цэнээ алдаагүй нь, нийгэм. олон нийтийн санаа бодлыг эрхшээсээр буй нь “Монголын” улс төрийн мэдээлэл харилцааны тэргүүлэгч “шүүлтүүр” хэзээд байхын баталгаа, нотолгоо мөн.

#### **НОМ ЗҮЙ**

- 1. Sampson.E , The image factor L.1994.
  - 2. Политическое консультирование M.1999
- Liberti.M Information Dominance II Strategic Forum. 1997 №132*

<sup>3</sup> Liberti.M Information Dominance II Strategic Forum. 1997 №132 p.132

ялгаатай. Сонгогч үг үйлдэл бүрийг нарийн нягталж, ойлгоод байдаггүй. Тэгээд ч сонгогч хүн багасгч улс төрийн мэдээлэл, харилцаанаас "зугтах" үгүйсгэх мөн чанартай болой. Тиймээс улс төрчлийн ярын, онцолж буй агуулгыг үнэлж дүгнэх бус харин нэгэнт тогтсон өөрийн байр суурь, төсөөлж бүхийг тодорхойлохыг эрмэлзэг. Улс төрчид ч тэрхүү олон нийтийн төсөөлөл, ойлголтоор эрэмбэлжээг. Харин тэрхүү эрэмбийг тогтоогчны ОНМХ байдаг. Өөрөөр хэлбэл бидний нийгэм цаг үе нь мэдээллийн, телевизийн, интернэтийн гэхээсээ илүү мэдээлэл, телевиз, интернэтийн бий болосон "бодит байдал, орон зай" болжээ.

Олон нийтгэй харилцах, сонгогчдыг татахад шинэ санаа, баримт, нотолгоо чухал юм. Тийнхүү учир зүйн нотолгоотой, "шугаман", зөв ончтой санаа дэвшүүлэх нь хошуучлагчийн олныг дагуулах үндэслэл, шалтгаан болно. 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Ц.Элбэсдорж "илүү хийн хийн, эхэлсэнээ гүйцээнэ" Б.Бат-Эрдэнэ "нэр цэвэр", С.Удвал "эмэгтэй хүн" гэсэн санааг нийгмээ хүрүүч нь сонгуулийн дүнгээр аль үнэ цэнэтэй вэ гэдгийг эрэмблэсн гэж хүйтэд угтуу

### **Дүгнэлт: Улс төрийн харилцааны опциог, 1р по.шо**

Улс төрийн имиж нь мэдээллийн давамгайлал, түшицэд гулгууржил зорилго, амжилтад хүрд ижам зарчимтай үйл хэрэг юм. Тиймээс ч мэдээллийн дайн дөвтглийн хэмжэх нэр томъёо гарч, болит амьдралд орших болсон. Мартын Либишки<sup>2</sup> "мэдээллийн давамгайлал" нь цэргэг дайши зорилго, давуу байдлын төлөөх түгээлт, тоөрөгдүүлэлт, хэрэгжүүний давуу байдлын бий болгох, харилцах үйл явц хэмээн тодорхойлсон нь улс төрийн харилцаанд ч алдил утгатай юм. Үүнийгээ түрээр гурван сийжүүлэх ойлголтын хүрээнд авч үзсэн ба ногдуулж мэдээллийн налдэг шууд үгүй хийх, өөрчлөх боломжгүй. Хоёрдугаарт өрсөлдөгч аль ч талууд мэдээллийн бодит орон зайыг түгээж ирж бодлого, үйл ажлыг агаагаа тодорхойлно, тэр дундаа хүчтэй газ нь илүү хүчин чармайлт гаргана. Гуравдугаарт хүний хүчин зүйл бүхийг тодорхойлно гэж томъёолжээ. Өөрөөр хэлбэл имисийн төлөөх өрсөлдөөн нь мэдээллийн давамгай түшицэд байр суурна тодорхойлох зорилго бодлого, үйл, асуудал гэсэн ѿг. Тэгээд ч энэхүү өрсөлдөөнт орчинд аль ньтг имиж, үзэл санаа ялах эсэх нь мэдээллийн давамгай түшиц, түүний нөлөөлдөөс шалтгаалдаг.

Ерөнхийлөгчийн албан тушаал бол улс төрийн дээд оргил, иэр хүнцэл имижийн тэргүүлэгч төвшин юм. Тиймээс ч Ерөнхийлөгчийн сойгуулийн компанийг ажил хүчин төгөлдөр Ерөнхийлөгчийн байр суурь давамгай, нэлдээ бүхий байдал. Ийм жишгэ АНУ-д Эйзенхауэр, Р.Никсон, Л.Жонсон, ОХУ-д В.В.Путин, В.Ельшин харилц Монголд Н.Багабанди, Ц.Элбэсдорж нарын дахиин сонгууль баталсан, Ернь ямарч улс орон нийгэм, улс төрийн имижийн гол үндэснээ загвар, хэмжээ төвшин Ерөнхийлөгчийнхөөр тодорхойлждан, АНУ-ын хувьд түр хүчин, эрч хүн эрч шийдвүүгийн байдал тэрүг нь Ерөнхийлөгчийн гол үндэснээ имиж байдал бол ОХУ-д энгийн, шууд, шударга, шийдвүүгийн, натуу чанс зарчимч чанарыг онцгойлон үзэг. Өөрөөр хэлбэл үндэсний зан тэгжхүйн онцлог, улс орны үнэт зүйл Ерөнхийлөгчийг тодорхойлох гол үнэтстэл шалгуур болдог.

Монголын улс төрийн PR-ын хошуучлагч (лидер) төвт үзүүлэний болсодул төрийг дээдтэгч байр суурь бүхий мэдээгээ харилцаа хэмжээ болно. Оноог хүргэж хошуучлагчийн төгс, эрхэмлэгт үзгэр жишээ, ухаан Чингис хаан, "Монголын цууц товчоо" хувьтээр байгаа нь, түүнээ өгүүлдэг үзэл санаа, үзэлжмж улс төрийн харилцаанд үнэ цээж алдаагүй нь, нийгэм, олон нийтийн санаа болтыг эрхшээсүүр буй нь "Монголын" улс төрийн мэдээлэл харилцааны түргүүлэгч "шүүгчүүр" хэзээд байхын багалгаа, нотолгое мөн.

### **НОМ ЗҮЙ**

1. Sampson.E. The image factor L. 1994.
  2. Политическое консультирование M.1999
- Liberty M Information Dominance II Strategic Forum 1997 №132*

<sup>2</sup> Liberty M Information Dominance II Strategic Forum 1997 №132 p.132